# Сэдэв: Инкотермсийн FAS нөхцөл



2018 он

# БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮРГЭЛТИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ



EXPORT DEVELOPMENT PROJECT

## Ачаалах боомтын тавцан хүргэх

1. Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг “худалдан авагчийн санал болгосон нэр бүхий боомтын тавцанд (ачих усан онгоцны хашлагын дагуух) хүргэх” нөхцөл.
2. Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг боомтын тавцанд хүргэснээр алдагдал, эвдрэл гэмтлийн эрсдэл худалдан авагч талд шилждэг.
3. Энэ нөхцөлийг зөвхөн далайн болоод дотоодын усан тээвэрт ашиглана.



# FAS НӨХЦӨЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТ, ХҮРГЭЛТ

Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчийн санал болгож сонгосон боомтын ачаа ачих тавцанд хүргэнэ. Буулгах үүрэггүй.




- FAS нөхцөлөөр худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчийн санал болгосон ачаалах боомтын тавцанд хүргэдэг.

- Боомтын тавцан гэдэг нь бараа, бүтээгдэхүүнийг ачих усан онгоцны хашлагын дагуух боомт дээр байрших ачаа хураах тавцанг хэлнэ. Худалдан авагч аль боомтын ямар нэртэй тавцанд бараа, бүтээгдэхүүнийг хүргэхийг санал болгодог.

# FAS НӨХЦӨЛИЙН ОНЦЛОГ ТАЛУУД

EXPORT DEVELOPMENT PROJECT

- Талууд даатгалын үүргийг бие биенийхээ өмнө хүлээдэггүй.
- Талууд хүргэлт хийх боомтыг нарийвчлан тохиролцох шаардлагатай. Үүнээс гадна боомт бүрийн үйлчилгээний нөхцөл, үнэ тариф өөр байдаг учраас талууд сонгосон боомтын үйлчилгээний талаар ижил ойлголттой байх шаардлагатай.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүний экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалтыг хариуцна.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг боомтод хүргэх анхдагч тээвэрлэлтийн гэрээг худалдан авагчийн зардал, эрсдлээр хийнэ.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг өөрийн байршлаас боомтын тавцанд хүргэхээс гадна боомтод нэгэнт хүргэгдэн ирсэн ижил бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч бэлэн болгож болдог. Ийм нөхцөл байдал нь талууд түүхий эдийн худалдаа хийж байгаа үед гардаг.
- Худалдан авагч импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалтыг хариуцна.

# FAS НӨХЦӨЛИЙН БҮДҮҮВЧ ЗУРАГЛАЛ






| Худалдагчийн зардал | Худалдан авагчийн зардал |
|---|---|
| Худалдагчийн эрсдэл | Худалдан авагчийн эрсдэл (бараа, бүтээгдэхүүн усан онгоцны хашлагын дагуух боомтын тавцанд хүргэгдсэнээс хойш) |

# FAS НӨХЦӨЛИЙН ДАГУУ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЗАРДАЛ

| Хүлээх үүрэг хариуцлага, зардал | ХУДАЛДАГЧ | ХУДАЛДАН АВАГЧ |
|---|---|---|
| 1. Барааны баглаа, боодол, тэмдэглэгээ, шошго | ✓ | ✗ |
| 2. Экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт | ✓ | ✗ |
| 3. Бараа, бүтээгдэхүүн хүргэлт хийгдсэнийг мэдэгдэх | ✓ | ✗ |
| 4. Анхдагч тээвэрлэлт (үндсэн тээвэрлэгч рүү)-ийг гэрээлэх, төлөх | ✗ | ✓ |
| Анхдагч тээврийн хэрэгсэлд ачих | ✓ | ✗ |
| Анхдагч тээврийн хэрэгслээс буулгах | ✗ | ✓ |
| 5. Үндсэн тээвэрлэлтийг гэрээлэх, төлөх | ✗ | ✓ |
| Үндсэн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах | ✗ | ✓ |
| 6. Эцсийн тээвэрлэлт (худалдан авагч **руу**)- ийг гэрээлэх, төлөх | ✗ | ✓ |
| Эцсийн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах | ✗ | ✓ |
| 7. Импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт | ✗ | ✓ |
| 8. Даатгал | ✗ | ✗ |

# FAS БОЛОН БУСАД НӨХЦӨЛҮҮД

Худалдагч | Худалдан авагч

| Талуудын хүлээх үүрэг, төлбөр, хариуцлага, эрсдэл | Бүх төрлийн тээвэр | | | | | | | Далайн болон дотоодын усан | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | EXW | FCA | CPT | CIP | DAT | DAP | DDP | FAS | FOB | CFR | CIF |
| Зардлын харьцуулсан хэмжээ $ | $ | $$ | $$$ | $$$ | $$$$ | $$$$ | $$$$$ | $$ | $$ | $$$ | $$$ |
| Барааны баглаа боодол | | | | | | | | | | | |
| Барааны тэмдэглэгээ, шошго | | | | | | | | | | | |
| Эскпортын зөвшөөрөл | | | | | | | | | | | |
| Ачаа дамжуулагчийн төлбөр | | | | | | | | | | | |
| Үндсэн тээвэрлэгч рүү хүргэх | | тохиролцоно | | | | | | | | | |
| Үндсэн терминалын хураамж | | | | | | | | | | | |
| Усан онгоцонд ачуулах хураамж | | | | | | | | | | | |
| Усан тээвэр/агаарын тээвэр | | | | | | | | | | | |
| Экспортын барааг дамжуулагчийг сонгох | | | | | | | | | | | |
| Далайн даатгал | Худалдааны гэрээгээр зохицуулна. | | | | Худалдааны гэрээгээр зохицуулна. | | | Худалдааны гэрээгээр зохицуулна. | | | |
| Үндсэн тээвэрлэгчээс ачааг буулгах хураамж | | | Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө. | | | | | | | Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө. | |
| Очих газрын терминалын хураамж | | | Тээвэрлэлтийн гэрээнээс шалтгаалж аль нэг тал төлнө | | | | | | | | |
| Тээвэрлэгчийг сонгох | | | Төлбөрийн нөхцөлөөс хамаарч аль нэг тал нь төлнө. | | | | | | | | |
| Хилээр орох шаардлагууд | | | | | | | | | | | |
| Гаалийн үзлэг шалгалтын төлбөр | | | | | | | | | | | |
| Гаалийн хураамж, Татвар | | | | | | | | | | | |
| Худалдан авагч руу хүргэх | | | Төлбөрийн нөхцөлөөс хамаарч аль нэг тал нь төлнө. | | | | | | | | |
| Ачааг буулгах | | | | | | | | | | | |

EXPORT DEVELOPMENT PROJECT

www.edp.mn

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА